



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 6 дугаар

Дугаар 201

Улаанбаатар

сарын 13-ны өдөр

ХОТ

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

**Улсын Их Хурлын 2010 оны 39, 2011 оны 53, 57
дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын**

Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг үндэсний аж ахуйн нэгжүүдэд худалдах, иргэдэд хувьцаа эзэмшүүлэх, иргэдийн хувьцааг Засгийн газар худалдан

авах үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжид худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 116 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлд дараахь агуулга бүхий 1.4 дэх заалт нэмсүгэй:

“1.4 Энэ тогтоолын 1.3-т заасны дагуу хасч тооцсон хувьцааны төлбөрийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК дахь хувьцааны төлбөр хүлээн авах тусгай дансанд төлсөн иргэнд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг буцаан эзэмшүүлэх”.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны тухай” Засгийн газрын 2012 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 181 дүгээр тогтоолын 5 дугаар зүйлд “төвлөрүүлж” гэсний дараа “Сангийн сайдын зөвшөөрснөөр захиран зарцуулахыг” гэснийг “Сангийн сайд болон Төрийн өмчийн хорооны зөвшөөрлөөр шилжүүлэхийг” гэж өөрчилсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Сангийн

сайд

Д.ХАЯНХЯРВАА